



Юта мужийн Бага эрсдэлийн түвшин

Энэ юу гэсэн утгатай вэ, та юу хийж чадах вэ?



Шар луу шилжиж байна

COVID-19-ийн тархалтыг удаашруулахад чиглэсэн Юта мужийн хүчин чармайлт үр дүнгээ өгч байна. Шинэ тогтсон хэвийн байдалд шилжинэ гэдэг тийм хурдан болох зүйл биш, энэ нь аажмаар, алгуурхан болох үйл явц юм.

Дахин асуудал үүсэхээс сэргийлж, Бага Эрсдэлийн (шар) түвшний олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах удирдамжийг үргэлжлүүлэн мөрдөнө үү.

Өндөр эрсдэлтэй хүмүүстэй нарийн зааварчилгааны дор харьцах ёстой, учир нь тэд COVID-19-н халдвар тараах өндөр эрсдэлтэй юм.

Ерөнхий удирдамж:



50 хүнтэй олон нийтийн цуглааны үед хүмүүсээс зай барих.



Олон нийтийн газар хүмүүсээс зай барих.




Хүмүүсээс зай барихад хэцүү үед амны хаалт зүүх.



Багын спортын тэмцээн эсвэл арга хэмжээний үеэр шинж тэмдэг байгаа эсэхийг шалгуулах.



2020/2021 оны хичээлийн жилд K-12 сургуулиудыг дахин нээх төлөвтэй байна.



Усан сангуудад бусад хүмүүсээс зай барих.



Арга хэмжээ болон зугаа цэнгээний газруудад өрх гэр бүл хоорондоо 6 тохой зай барих.



Өрх гэр бүл хоорондын зай барих, хэд хэдэн удаагийн бага хэмжээний цуглаан зохион байгуулах болон боломжтой бол шууд дамжуулалт хийх.



CORONAVIRUS
UTAH.GOV

Байгууллагуудад зориулсан ерөнхий удирдамж:

— БИД — “НЭЭЛТТЭЙ”

Бизнесийн бүх үйл ажиллагаа нээгдэх ба зохих урьдчилсан сэргийлэх арга хэмжээнүүдийг авах.



Хоолны үйлчилгээ нь зохих эрүүл ахуйн шаардлага дор нээгдэх ба хүмүүсээс зай барих шаардлагатай.



Ажлын уян хатан зохицуулалтыг дэмжих, эрүүл ахуйн зөвлөмжүүдийг дагах болон ажлын байранд бусад хүмүүсээс зай барих.

Өндөр-Эрсдэлтэй Хүмүүс:

- ✓ Хүмүүсээс зай барих бусад арга хэмжээнүүдийг авахад хэцүү үед амны хаалт зүүх
- ✓ Аливаа аялал зугаалгын үед, зохих урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авах; өндөр эрсдэлтэй газруудаас зайлсхийх
- ✓ Боломжтой бол гэрээсээ ажиллах, хэрэв боломжгүй бол бусдаас 6 тохой зай барих
- ✓ Хэрэв найз нөхөд эсвэл гэр бүлийнхнээрээ зочлох бол 6 тохой зай барьж, амны хаалт зүүх
- ✓ Таны гэр бүлийн эсвэл хамт оршин суудаг хүмүүсээс бусад өндөр эрсдэлтэй хүмүүстэй биеэр харьцахыг хязгаарлах
- ✓ Өөрийн гэр эсвэл оршин суугаа газраас гадуур 20 эсвэл түүнээс цөөн хүнтэй нийгмийн харилцаанд орох
- ✓ Эмнэлэг, асрамжийн газар эсвэл бусад эмнэлгийн тусламжийн газруудаар явахыг хязгаарлах

Хүүхдүүд:

- ✓ Олон нийтийн газар бусад хүмүүсээс зай барих
- ✓ Шинж тэмдэг бүхий хүүхдүүд өдөр өнжүүлэх төвд явалгүй гэртээ байх бөгөөд ямар нэгэн шинж тэмдэг илэрвэл гэрт нь буцаах
- ✓ Хүүхдүүдийг олон нийтийн газар (тоглоомын талбайн тоног төхөөрөмжүүд гэх мэт) бусад хүүхдүүдтэй харьцахыг хязгаарлах

Хувь хүн болон бизнесийн байгууллагад зориулсан дэлгэрэнгүй зааварчилгааг Coronavirus.Utah.gov-с авна уу

